

МОНГОЛ УЛС, ӨВӨР МОНГОЛЫН АРД ТҮМНИЙ СОЁЛЫН ХАРИЛЦААНЫ ТҮҮХЭЭС

*Ч.Батцэцэг**

БНХАУ-ын үндэстний өөртөө засах анхны орон болох Өвөр Монголын Өөртөө Засах Орон (ӨМӨЗО) 1949 оны 5 дугаар сарын 1-нд байгуулагдсан юм. ӨМӨЗО байгуулагдсаны дараахи хамгийн чухал зорилт бол орон нутагтаа ардчилсан өөрчлөн байгуулалт хийх явдал байлаа. Өөрчлөн байгуулалтанд улс төр, эдийн засаг, соёл гэгээрлийн бүх салбарыг хамруулж, шат дараалсан арга хэмжээ авч явуулжээ.

Өвөр Монголын өөрчлөлтийн чухал хэсэг бол соёлын хоцрогдлыг арилгаж, монгол угсаатны биеэ даасан соёлын дэвшилт уламжлалын үндсэн дээр хувьсгалт шинэ утга зохиол, урлаг, ардын гэгээрэл, эрүүлийг хамгаалах албыг үүсгэн хөгжүүлэх явдал байв.¹

ӨМӨЗО байгуулагдахаас өмнө нутгийн монголчуудын 90-ээд хувь нь бичиг үсэг тайлагдаагүй байсан учир ӨМӨЗО-ы Ардын засгийн газар ард түмнийг үндэсний бичиг үсэгт сургах бүлгэм, дугуйлан, түр сургууль, бага, дунд сургууль байгуулах талаар ихээхэн анхаарч байсан ажээ. Олон шатны сургуулиуд байгуулагдахын сацуу БНМАУ-ын соёлын байгуулалтын туршлагыг судалж нэвтрүүлэх ажлыг зохион байгуулж байлаа. 1948 оны 4 дүгээр сарын 1-ээс хэвлэгдэн гарсан “Ардын мэдэл” сэтгүүл анхныхаа дугаараас эхлэн монгол шинэ үсгийн (кирилл үсэг) хичээл зааж эхэлсэн байна.² БНМАУ-ын ерөнхий боловсролын сургуулийн зарим сурах бичгийг ӨМӨЗО монгол үсгээр хэвлэж олшруулаад сургуулиудад тараан өргөн хэрэглэх болжээ. Тухайлбал: профессор Ш.Лувсанвандангийн “Монгол хэлний зүй” ном сургалтын үндсэн гол хэрэглүүр болж байжээ.

1949 оны 10 дугаар сарын 1-нд БНХАУ байгуулагдмагц манай улс дипломат харилцаа тогтоосон хоёрдахь орон болов. 1950 оны 6 дугаар сард БНМАУ-аас БНХАУ-д суух анхны элчин сайд томилогдож, БНХАУ-ын дарга Мао Цзэдунд итгэмжлэх жуух бичгээ барилаа. Энэ үеэр Хятадын Ардын засгийн газрын ГЯЯ-ны сайд Чжоу Эньлай: “... та нар Өвөр Монголынхонтой өргөн харилцаа тогтоох хэрэгтэй, нэг хэл бичигтэй улс шүү дээ”³ гэж хэлж байснаас үзэхэд шинэ тулгар Хятад орны хувьд манай улстай харилцахдаа монголчуудын хэл бичиг, түүх, соёлын онцлог, мал аж ахуй эрхэлдэг уламжлал зэргийг харгалзан Өвөр Монголоор дамжуулан хоёр орны харилцааг түлхүү хөгжүүлэх зорилготой байсан мэт.

*Ч.Батцэцэг - ОУСХ-ийн эрдэм шинжилгээний ажилтан, магистр

1950 оны 7 дугаар сард БНХАУ-аас БНМАУ-д суух онц бөгөөд бүрэн эрхт элчин сайд Заяатай (Зи Яатай) БНМАУ-ын Улсын Бага Хурлын Тэргүүлэгчдийн дарга Г.Бумцэндэд итгэмжлэх жуух бичиг барив. Элчин сайд, Х.Чойбалсантай уулзахдаа: "... Би өөрөө түмэд монгол хүн шүү дээ. Нөхөр Мао Цзэдун монголчуудын тухай их анхаардаг бөгөөд түүний баримт бол хэдүй миний бие монгол хүн боловч миний биеийг Монгол улсад элчин сайдаар томилон суулгаж байгаа явдал болно."⁴ гэжээ. Хятад улс БНХАУ-ын нутаг дэвсгэр дэх монголчууд ялангуяа өвөр монголчуудын байр суурь, үзэл санаанд Ар Монгол нөлөөлөх нь зайлшгүй учраас энэ талаар маш их анхаарч, Монгол улстай харилцахдаа аль болохоор монгол үндэстэн томилж явуулж байсан.

Ийнхүү БНМАУ, БНХАУ-ын хооронд дипломат харилцаа тогтоосноос хойш хоёр орны ард түмний найрамдалт харилцаа бүхий талаар өргөжин хөгжих болов. 1951 оноос хоёр орны хооронд багш оюутан солилцож эхэлсэн юм. 1952 онд Монгол, Хятадын эдийн засаг, соёлын хамтын ажиллагааны анхны гэрээ байгуулагдав.

Үүний үр дүнд 1953 онд БНМАУ-ын зуу гаруй хүнтэй урлагийн томоохон хэсэг БНХАУ, Өвөр Монголын нутгаар айлчлан тоглож, түүнээс хойш БНМАУ-ын цирк, Ардын Цэргийн дуу бүжгийн чуулга, Ховдын хөгжимт драмын театрын жүжигчид тоглолт хийлээ. Хятадын Ардын Чөлөөлөх Армийн чуулга, Өвөр Монголын дуу бүжгийн чуулга, Хүүхэлдэйн театрын жүжигчид зэрэг урлагийн бусад хамтлагууд Монголд ирж байсан нь хоёр орны соёлын харилцаа өргөжин тэлж байсны илрэл юм.

Нөгөөтэйгүүр Хятадын удирдагчид монголчуудын сэтгэлийг татахын тулд үндэсний үзэл, Чингис хааныг хүндэтгэх талаар нэлээд арга хэмжээ авч байв. 1954 оны 4 дүгээр сард Чингис хааны нас барсны 727 жилийн ойн дурсгалт өдөр Өвөр Монголд хурал хийж, Ордосын Эзэн Хороо хэмээх газар Чингисийн онгон тахил бариулах шийдвэр гаргаж⁵ 1955 онд бүрэн баригдаж дууссан байна.

50-иад оны дунд үеэс ӨМӨЗО-д монголын шинэ үсэг сурах хөдөлгөөн эрчимтэй өрнөж, нутгийн монгол үндэстнүүд амжилттай сурч байв. 1955 оны 5 дугаар сард монгол хэл бичгийн асуудлаар эрдэм шинжилгээний хурал болж, шинэ монгол бичгийг дэлгэрүүлэхийн зайлшгүй чухал хэрэгцээг шинжлэх ухааны үүднээс тогтоон гаргасны дараа мөн оны 7 дугаар сард ӨМӨЗО-д шинэ монгол үсэг сурах тухай албан ёсны шийдвэр гарчээ. 1956 оны 9 дүгээр сараас Өвөр Монголын

ерөнхий боловсролын сургуульд шинэ монгол бичгийг албан ёсоор үзэж эхэлсний сацуу шинэ монгол үсгийн дугуйлан олноороо байгуулагдаж байсан. 1957 оны 4 дүгээр сарын байдлаар ӨМӨЗО-ы монгол кадр ажилтны 50 хувь нь шинэ үсгийн оройн дугуйланд хамрагдан суралцсан⁶ гэсэн тооцоо гарчээ.

БНМАУ, ӨМӨЗО-ы ард түмний түүх, соёлын уламжлалт харилцаа улам өргөн хүрээтэй болж ирэв. 1959 оны 9 дүгээр сард Улаанбаатар хотноо болсон Олон улсын монголч эрдэмтдийн (ОУМЭ) анхдугаар хуралд 15 улсын 40 гаруй эрдэмтэн оролцсоны дотор Хятад, Өвөр Монголын профессор Вэн Дуцзян, Чингэлтэй, Эрдэнэтогтох, Цюй Фу нарын эрдэмтэд ирж байсан бол түүнээс хойш уг хуралд Өвөр Монголын эрдэмтэн судлаачид олноороо тогтмол оролцох болсон юм. ӨМӨЗО байгуулагдсан түүхийн шинэ нөхцөлд Монголын түүхийг тусгайлан судлах ажил мөн тавиад оны үеэс эхэлсэн агаад 1958 онд Өвөр Монголын түүх судлах газар, олон нийтийн эрдэм шинжилгээний байгууллага “Өвөр Монголын түүхийн нийгэмлэг” байгуулагджээ.

Өвөр Монголын Ардын Хэвлэлийн Хороо монголын эртний уран зохиол, аман зохиол болон БНМАУ-ын шилдэг зохиолуудыг орчуулан хэвлэн нийтэлж байв. “Монгол хэл, зохиол, түүх” хэмээх сар тутмын тогтмол сэтгүүлдээ БНМАУ-ын эрдэмтдийн бүтээлээс танилцуулах болжээ. Үүний зэрэгцээ БНМАУ-д өргөн дэлгэрсэн дуунуудыг Өвөр Монголд түгээн дэлгэрүүлэх хөдөлгөөн өрнүүлж, монгол, хятад хэлээр дуулсгааж байв. 60-аад оны үед манай зохиолчдын “Сэлэнгэ мөрөн”, “Сайхан Монгол орон”, “Баян Монгол”, “Эх орон” зэрэг дуу Өвөр Монголд өргөн тархаж, өдгөө хүртэл дуулагдсаар байна.

Ийнхүү хоёр орны ард түмний соёлын уламжлалт харилцаа улам өргөжин тэлж, найрамдан нөхөрлөж байсан сайхан үе удаан үргэлжилсэнгүй. БНХАУ-д өрнөсөн “Соёлын хувьсгал”-ын жилүүдэд өөрөөр хэлбэл 1960-аад оны сүүлч 80-аад оны дунд үе хүртэл хоёр орны харилцаа үндсэндээ бүрэн тасарсан юм. “Соёлын хувьсгал”-ын жилүүдэд БНХАУ-д БНМАУ-ын түүхийг гуйвуулах гэсэн үйл ажиллагаа идэвхжиж, уг ажлын хүрээнд Өвөр Монголын эрдэмтэн судлаачдыг аль болохоор зохиогчоор хамруулах оролдлого хийж, ном, товхимол, сурах бичиг, газрын зураг олноор нь хэвлэн нийтэлж байв. Манай эрдэмтэн судлаачид ч мөн ялгаагүй маоизмын эсрэг бичиж, хэвлэж, үзэл суртлын хувьд сөргөлдсөн үе байсан.

БНХАУ 1978 оноос өөрчлөлт шинэчлэл, нээлттэй бодлого явуулж эхэлсний үр дүнд олон жил хаалттай байсан манай хоёр орны харилцаа аажмаар тавигдаж эхлэв. Хориод жил царцанги байсан харилцаа 1985 оны 9 дүгээр сард ӨМӨЗО-ы дуу бүжгийн “Улаан мөчир” чуулгынхан Монгол улсад тоглолт хийж монгол элгэн садан нартаа ая дууны дээж өргөснөөр бүлээрч эхэлсэн юм. БНМАУ, БНХАУ-ын Засгийн газрын хооронд 1986 оны 6 дугаар сард соёлын солилцоо, хамтын ажиллагааг хэрэгжүүлэх төлөвлөгөөнд гарын үсэг зурав. Үүнээс хойш соёл урлагийн салбарт соёлын өдрүүд зохион байгуулах, хамтарсан тоглолт хийх, урлаг соёлын ололтын үзэсгэлэн гаргах, кино долоо хоног зэрэг олон талын хамтын ажиллагаа явуулах болжээ. БНХАУ-ын Соёлын Яамны урилгаар БНМАУ-ын соёл урлагийн төлөөлөгчид 1988 онд Өвөр Монголд тоглолтоо хийж өвөр монголчуудыг бишрүүлсэн билээ. 80-аад оны үед Өвөр Монголын дуучид, жүжигчид Бүх Хятадын хэмжээнд зохиогддог уралдаан тэмцээнд идэвхтэй оролцож байснаас Өвөр Монголын дуучин Гэрэлтү Монголын яруу найрагч Ж.Бадраагийн үг, Батсүхийн ая “Гайхмаараа” дуугаар Бүх Хятадын тэргүүн зэргийн дуучин цол хүртэж байлаа.

МХНН, ХМНН түүний Өвөр Монгол дахь салбар болон гадаадтай соёлоор харилцах нийгэмлэг зэрэг бусад олон нийтийн байгууллагуудын үйл ажиллагаа сэргэж, идэвхтэй ажиллах болов. Улаанбаатар хотноо Өвөр Монголын Хэвлэлийн газруудын номын үзэсгэлэн, Хөх хотод манай улсын номын үзэсгэлэн, гэрэл зургийн үзэсгэлэн анх удаа гарч олны сонирхлыг ихэд татаж байлаа.

Хоёр талын хил залгаа аймаг, хот, сумдын хооронд шууд харилцаа тогтож, орон нутгийн хэмжээнд бие даан үйл ажиллагаа явуулдаг болжээ. Тухайлбал: Дорнод аймгийн Хөлөнбуйр сумын соёлын төвийн уран сайханчид хилийн дээс алхаж, аймгийнхаа хөрш ӨМӨЗО-ы Хөлөнбуйр аймгийн хоёр хошуунд тоглов. Тэд Ч.Лодойдамбын зохиол “Ёс ёмбогор, төр төмбөгөр” жүжиг, уран сайханчдын концерт тоглож олны талархал хүлээв.⁷ гэх мэтийн жишээ баримтыг 90-ээд оноос хойшхи сонин хэвлэлийн бараг өдөр бүрийн дугаараас уншиж болно.

Ийнхүү Монгол улс, ӨМӨЗО-ы хоорондын соёл урлагийн салбарын үйл ажиллагаа тасралтгүй үргэлжлэн хөгжиж байна. Өнөөдөр Монголын ард түмэн Өвөр Монголын алдарт дуучин Лхасүрэн, Тэнгэр, Дэдмаа, морин хуурч Чи Булаг, жүжигчин Дэлгэр нарын олон алдартныг мэдэх болжээ. Харин Өвөр Монголд манай улсын “Морин хуурын чуулга”, хөгжмийн зохиолч Н.Жанцанноров, дуучин

Норовбанзад, Долгор, Чимэдцэеэ, Сарантуяа болон эстрадын хамтлагууд “Чингис хаан”, “Хурд” зэргийг мэдэхгүй хүнгүй болсон байна. Ялангуяа сүүлийн жилүүдэд монголын соёл урлагийн арга хэмжээ Өвөр Монголд эрчимжиж дуучид, жүжигчид, хамтлагууд хувиараа болон албаны журмаар айлчлан тоглолт хийсээр байна.

Хоёр орны соёл урлагийн салбарын хамтын ажиллагаанд тухайн оронд зохиогддог соёлын өдрүүд, кино, радио телевизийн өдрүүд онцгой чухал байр эзэлдэг. Монгол улс, Өвөр Монголын киноны уран бүтээлчид хэд хэдэн кино хамтран бүтээсэн. Эдгээр кино дэлгэцнээ гарч, кино солилцох, жүжигчид солилцох зэрэг үйл ажиллагаа явуулж ирлээ. Монголын зохиолч Ц.Нацагдорж, Өвөр Монголын зохиолч М.Наянтай нарын зохиолоор Г.Жигжидсүрэн “Өс хонзон” уран сайхны кино найруулж, хөгжмийг Өвөр Монголын алдарт дуучин С.Тэнгэр бичиж, дуулжээ. Мөн “Ганган хар буюу монголын талд” хэмээх хамтарсан уран сайхны кинонд Монгол улсын ардын жүжигчин Долгорсүрэн, Өвөр Монголын алдарт дуучин Тэнгэр нар гол дүрд тоглож, 1996 онд олон улсын кино-наадмаас шагнал хүртсэн ажээ. Өвөр Монголын сар шинийн уламжлалт баярын үйл ажиллагаанд манай улсын телевизийн хөтлөгч, нэвтрүүлэгчид, яруу найрагчид, жүжигчид, дуучид, хамтлагууд оролцдог нь уламжлал болж, хоёр орны ард түмний хүсэл мөрөөдөл, зүрх сэтгэлийн хөгийг ойртуулж, зууны манлай дуу болж хөшөөнд мөнхөрсөн “Халуун элгэн нутаг” дуу нийт монголчуудын сүлд дуулал болж байгаа нь үндэс угсаа, садан төрлийн холбооны онцлог гэхээс өөр аргагүй.

ИШЛЭЛ, ЗҮҮЛТ

1. “Нэймэнгу гэминь ши” (Өвөр Монголын хувьсгалын түүх). ӨМИС-ийн хэвлэл. 1997 он. т. 607
2. “Хятад дахь монголчууд” УБ., 1996. т.83
3. Б.Жаргалсайхан. Алаг жарны бодрол. УБ., 2001 он. т.58
4. Б.Цэрэндорж. Хязгааргүйгээс эрэхүй олохуй. Бээжин хот., 2000. т.37
5. Rupen. The Mongolian Peoples Republic and Sino-Soviet Competition. pp.272-73
6. “Нэймэнгу да цидянь” (Өвөр Монголын их толь бичиг). Хөххот. 1989. т.208-217
7. “Ардын эрх” сонин 1993.7.20 №13 (613)